



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/138

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хаврын улиралд үүсч болзошгүй махны хомсдол, үнийн хэт өсөлтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нөөцөлсөн махыг зах зээлийн үнээс хямд өртгөөр борлуулсан 1 кг тутамд урамшуулал олгох, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ц.Чогсомжав	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүн:	С.Нямдаваа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231040372